




ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН
ТАЙЛАН

Аудитын код: ХӨА-2022/61/НА-СТА-ТШЗ

Хөвсгөл аймаг
Мөрөн сум
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг. Мөрөн сум
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvs gul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.02.23 № 01/М
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАШААНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.ОТГОНЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЗБААТАР





2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	75,157,374.00	98,858,319.00
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	1,411,790.00	1,411,790.00
335	Бусад авлага	1,411,790.00	1,411,790.00
3351	Байгууллагаас авах авлага	1,411,790.00	1,411,790.00
35	БАРАА МАТЕРИАЛ	73,745,584.00	97,446,529.00
354	Хангамжийн материал	73,745,584.00	97,446,529.00
35410	Бичиг хэргийн материал	2,540,485.00	2,112,885.00
35420	Аж ахуйн материал	63,925,099.00	87,803,644.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	250,000.00
35470	Бусад хангамжийн материал	7,280,000.00	7,280,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	774,499,399.10	900,564,010.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	774,499,399.10	900,564,010.40
392	Биет хөрөнгө	719,191,357.75	843,513,719.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	588,400,920.00	649,936,980.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-125,585,613.63	156,747,151.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	190,519,203.00	83,813,655.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-167,368,682.64	-37,675,005.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	159,754,729.00	115,965,123.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,324,540.95	-40,933,910.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,930,944.00	42,428,483.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,882,638.37	-24,885,755.39
39209	Зам, гүүрийн байгууламж	28,687,500.00	28,687,500.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-9,112,500.00	-13,668,750.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	19,384,038.00	19,384,038.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	159,859,783.00	259,672,765.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-45,071,783.66	-82,464,253.02
393	Биет бус хөрөнгө	55,308,041.35	57,050,291.27
39301	Программ хангамж	5,427,000.00	3,373,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,684,812.65	-889,062.73
39303	Бусад биет бус хөрөнгө	54,565,854.00	54,565,854.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	849,656,773.10	999,422,329.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,000,000.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,000,000.00	00.00
413	Өглөг	1,000,000.00	00.00
4136	Бусад өглөг	1,000,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,000,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	848,656,773.10	999,422,329.40
51	Засгийн газрын хувь оролцоо	848,656,773.10	999,422,329.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	461,847,337.00	461,847,337.00
51101	Өмч: - төрийн	461,847,337.00	461,847,337.00
512	Хуримтлагдсан үр дүн	261,543,461.91	412,309,018.21
51210	Өмнөх үеийн үр дүн	261,543,461.91	261,543,461.91
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	150,765,556.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	125,265,974.19	125,265,974.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	849,656,773.10	999,422,329.40



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	486,418,389.00	657,894,157.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	96,836,616.00	266,180,349.10
120	Нийтлэг татварын бус орлого	96,836,616.00	249,627,899.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	96,836,616.00	249,627,899.10
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	96,836,616.00	249,627,899.10
122	Тусламжийн орлого	00.00	16,552,450.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	16,552,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	389,581,773.00	391,713,808.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,406,373.00	13,394,108.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,000,000.00	5,399,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,018,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,898,373.00	7,784,608.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	490,000.00	210,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	380,175,400.00	378,319,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	380,175,400.00	378,319,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	462,080,860.24	507,128,600.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	462,080,860.24	507,128,600.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	453,019,791.24	503,581,574.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,972,300.00	241,230,000.00
210101	Үндсэн цалин	216,625,900.00	184,362,500.00
210102	Нэмэгдэл	00.00	56,867,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,346,400.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,097,300.00	32,566,100.00
210201	Тэтгэврийн даатгал	22,423,600.00	22,916,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,418,500.00	2,412,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,934,700.00	1,929,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	483,700.00	482,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,836,800.00	4,824,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,772,200.00	28,856,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	5,409,438.00
210302	Түлш, халаалт	8,272,200.00	21,340,562.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	2,106,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,666,854.00	47,862,727.00
210401	Бичиг хэрэг	3,468,750.00	2,219,490.00
210402	Тээвэр, шатахуун	21,953,304.00	13,884,182.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,400,000.00	5,474,100.00



210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,599,900.00	9,845,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	11,997,250.00
210408	Бараа материал акталсны зардал	3,244,900.00	4,442,205.00
2105	Нормативт зардал	2,646,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	00.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,646,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	4,496,000.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	4,496,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,234,000.00	851,300.00
210702	Дотоод албан томилолт	1,234,000.00	851,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,309,400.00	32,970,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,435,400.00	32,235,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	180,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,000.00	146,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	896,000.00	342,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,821,737.24	114,447,947.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,762,000.00	14,191,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,893,600.00	1,088,110.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,166,137.24	99,168,387.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,061,069.00	3,547,026.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,149,069.00	3,547,026.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,149,069.00	3,547,026.00
2134	Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,912,000.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,912,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	24,337,528.76	150,765,556.30
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,268,650.22	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	25,268,650.22	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-25,268,650.22	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-931,121.46	150,765,556.30

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	461,847,337.00	125,265,974.19	261,543,461.91	848,656,773.10
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	461,847,337.00	125,265,974.19	261,543,461.91	848,656,773.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00



D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	461,847,337.00	125,265,974.19	261,543,461.91	848,656,773.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	150,765,556.30	150,765,556.30
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	461,847,337.00	125,265,974.19	412,309,018.21	999,422,329.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	389,581,773.00	391,713,808.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	389,581,773.00	391,713,808.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,406,373.00	13,394,108.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,000,000.00	5,399,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,018,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,898,373.00	7,784,608.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	490,000.00	210,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	380,175,400.00	378,319,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	380,175,400.00	378,319,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	378,984,373.00	391,713,808.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,984,373.00	391,713,808.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,923,304.00	387,166,782.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,972,300.00	241,230,000.00
210101	Үндсэн цалин	216,625,900.00	184,362,500.00
210102	Нэмэгдэл	00.00	56,867,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,346,400.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,097,300.00	32,566,100.00
210201	Тэтгэврийн даатгал	22,423,600.00	22,916,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,418,500.00	2,412,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,934,700.00	1,929,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	483,700.00	482,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,836,800.00	4,824,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,000,000.00	29,106,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	5,409,438.00
210302	Түлш, халаалт	7,500,000.00	21,590,562.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	2,106,800.00



2104	Хангамж, бараа материалын зардал	40,990,704.00	37,219,882.00
210401	Бичиг хэрэг	4,037,500.00	1,770,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,953,304.00	13,884,182.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,400,000.00	5,474,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,599,900.00	9,845,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	6,246,100.00
2105	Нормативт зардал	2,100,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	00.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,100,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	6,916,000.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	6,916,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,234,000.00	851,300.00
210702	Дотоод албан томилолт	1,234,000.00	851,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,516,400.00	37,866,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,642,400.00	37,131,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	180,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,000.00	146,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	896,000.00	342,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,512,600.00	1,110,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,810,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,702,600.00	1,110,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,061,069.00	4,547,026.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,149,069.00	4,547,026.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,149,069.00	4,547,026.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,912,000.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,912,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,597,400.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,597,400.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,597,400.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,597,400.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,597,400.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,597,400.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	378,319,700.00	378,319,700.00	-	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,319,700.00	378,319,700.00	-	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,219,700.00	374,219,700.00	-	100%



Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,230,000.00	241,230,000.00	-	100%
210101	Үндсэн цалин	184,362,500.00	184,362,500.00	-	100%
210102	Нэмэгдэл	56,867,500.00	56,867,500.00	-	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,566,100.00	32,566,100.00	-	100%
210201	Тэтгэврийн даатгал	22,916,900.00	22,916,900.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	2,412,300.00	2,412,300.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,929,800.00	1,929,800.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	482,500.00	482,500.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,824,600.00	4,824,600.00	-	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,000,000.00	27,000,000.00	-	100%
210301	Гэрэл, цахилгаан	6,500,000.00	5,409,438.00	1,090,562.00	83%
210302	Түлш, халаалт	20,500,000.00	21,590,562.00	(1,090,562.00)	105%
2104	Хангамж, бараа материалын зардал	28,679,600.00	28,679,600.00	-	100%
210401	Бичиг хэрэг	1,560,000.00	1,560,000.00	-	100%
210402	Тээвэр, шатахуун	12,100,000.00	12,100,000.00	-	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,220,000.00	5,474,100.00	(254,100.00)	105%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,599,600.00	7,345,500.00	254,100.00	97%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,200,000.00	2,200,000.00	-	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,916,000.00	6,916,000.00	-	100%
210604	Урсгал засвар	6,916,000.00	6,916,000.00	-	100%
2107	Томилолт, зочны зардал	851,300.00	851,300.00	-	100%
210702	Дотоод албан томилолт	851,300.00	851,300.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,866,700.00	35,866,700.00	-	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,131,300.00	35,131,300.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	180,000.00	-	100%



210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,600.00	146,600.00	-	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00	-	100%
210807	Газрын төлбөр	342,800.00	342,800.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
		1,110,000.00	1,110,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,110,000.00	1,110,000.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
		4,100,000.00	4,100,000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг				
		4,100,000.00	4,100,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,100,000.00	4,100,000.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
		378,319,700.00	378,319,700.00	-	100%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
		378,319,700.00	378,319,700.00	-	100%
132001	Орон нутгийн төсвөөс	378,319,700.00	378,319,700.00	-	100%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
		00.00	00.00	00.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
		00.00	00.00	00.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
		00.00	00.00	00.00	
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
		23.00	23.00	00.00	100%
620001	Удирдах ажилтан	08.00	08.00	00.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	00.00	100%
620004	Гэрээт ажилтан	03.00	03.00	00.00	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,394,108.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,394,108.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,947,082.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,106,800.00
210303	Цэвэр, бохир ус	2,106,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,540,282.00



210401	Бичиг хэрэг	210,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,784,182.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,046,100.00
2105	Нормативт зардал	300,000.00
210502	Хоол, хүнс	300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	447,026.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	447,026.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	447,026.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,394,108.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,394,108.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,399,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,784,608.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	210,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолтой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 3/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Рашаант сумын Засаг даргын Тамгын газар нь “Сумын Засаг дарга, ИТХ-ын хуралд мэргэшлийн өндөр зөвлөгөө мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх замаар үйлчилж, нутгийн захиргааны үр дүнтэй, хэвийн үйл ажиллагааг төлөвшүүлэн хөгжилд дэвшилд хүрэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна. Уг зорилгын хүрээнд 2 хөтөлбөр, 5 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхуйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын хүлээгдэж буй гүйцэтгэл 462.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 149.8 сая төгрөгөөр буюу 17.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	1.4	1.4	0.0
Урьдчилгаа			-
Бараа материал	73.8	97.5	23.7
Үндсэн хөрөнгө	774.5	900.6	126.1
Нийт хөрөнгө	849.7	999.4	149.8
Өр төлбөр	1.0	0.0	-1.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	848.7	999.4	150.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	849.7	999.4	149.8

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх он болон тайлант онд үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл болох 1.4 сая төгрөг нь халаалтын төлбөрийн тарифын зөрүүгээс үүссэн Арвай илч ХХК-аас авах авлага байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дээрх авлагыг барагдуулах зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 97.5 сая төгрөг болж 23.7 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалын дансанд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 19.7 сая төгрөгийн зөгий үржүүлэх төслийн хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 900.6 сая төгрөг болж 126.1 сая төгрөгөөр өссөн байна. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 94.0 сая төгрөгийн гэрэлтүүлэг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 61.5 сая төгрөгийн биологийн цэвэрлэх байгууламжийг хүлээн авсан нь үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны өмнөх оны үлдэгдэл болох үлдэгдэл 1.0 сая төгрөгийн өр төлбөрийг төлж барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 999.4 сая төгрөг болж, тайлант үеийн үр дүн болох 149.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 379.5 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны төсвийг 338.2 сая төгрөгөөр төсөв баталснаас 338.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Рашаант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор анх баталсан төсвийг 40.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 378.3 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 378.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 378.3 сая төгрөгийг буюу төсвийг 100% зарцуулж ажилласан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байгаа тул зөвлөмж хүргүүлэв.

Тухайн байгууллагын төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр харуулбал:

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр

№	Хөтөлбөрийн код, нэр	Арга хэмжээний код, нэр	Зардлын дүн		Зөрүү
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	70106 Орон нутгийн гүйцэтгэх удирдлага	80101 Үндсэн үйл ажиллагаа	283.5	283.5	0.0
		80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	55.5	55.5	0.0
		80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	4.1	4.1	0.0
		81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	22.1	22.1	0.0
2	71413 байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	8.0	8.0	0.0
Нийт дүн			378.3	378.3	0.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсөв захирагчаас 7.8 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс 5.4 сая төгрөгийн хандив тусламж, төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого 0.2 сая төгрөг, нийт 13.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Дээрх нэмэлт санхүүжилтийн орлогыг холбогдох байгууллага, албан тушаалтны удирдамж шийдвэрийн дагуу зохих зардалд зарцуулах эрхийг нээлгэж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Рашаант сумын Засаг даргын Тамгын газар нь Төсвийн гүйцэтгэлийн тайланг тайлагнахдаа баримталж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн программаас шалтгаалан Төсвийн тодотгол хийсэн байхад Төсвийн гүйцэтгэлийн тайланг анх батлагдсан төсөвтэй харьцуулан тайлагнаагүй, төсвийг нэмсэн шалтгаан нөхцөлийг тодруулаагүй байна. Энэ нь УСНББОУС 24-ийн Параграф 14, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.4 “Төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон



бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх"-т заасантай нийцэхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Рашаант сумын Засаг даргын Тамгын газар Арвай илч ХХК-аас авах халаалтын үнийн тарифын зөрүү болох 1.4 төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 6.4.8 дах "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" нийцэхгүй байна. Мөн өмнөх аудитаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар Рашаант сумын Засаг даргын Тамгын газрыг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Рашаант сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 378.3 сая төгрөгийн 48 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 378.3 сая төгрөгийн 48 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж 1 зөвлөмжийг 50 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж, авлага барагдуулах 1 албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийгээгүй болно.

4.2 Зөвлөмж

1.1 Илрүүлэлт:

ЗДТГ-ын төсвийн зардлаар 0.8 төгрөгөөр уулзалт зөвлөгөөн, 0.5 төгрөгөөр тэмцээн уралдааны зардал гаргасан, тогтмол зардлын болон нийт төсвийн гүйцэтгэлээр хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1, 1.6, 1.8 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Засгийн газар болон бусад эрх бүрий байгууллагаас тухайн жилийн төсөвтэй холбоотой гаргасан тогтоол, тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Рашаант сумын Засаг даргын Тамгын газар	2	2.7					1	1.4	1	1.3

4.2 Зөвлөмж

1.1 Илрүүлэлт:

ЗДТГ-ын төсвийн зардлаар 0.8 сая төгрөгөөр уулзалт зөвлөгөөн, 0.5 сая төгрөгөөр тэмцээн уралдааны зардал гаргасан, тогтмол зардлын болон нийт төсвийн гүйцэтгэлээр хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1, 1.6, 1.8 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Засгийн газар болон бусад эрх бүрий байгууллагаас тухайн жилийн төсөвтэй холбоотой гаргасан тогтоол, тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Рашаант сумын Засаг даргын Тамгын газар	2	2.7					1	1.4	1	1.3

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Э.БАТ-ЭРДЭНЭ ОГНОО: 2/23

Л.МАНДАХНАРАН ОГНОО 11/22